



САНГИЙН ЯАМ



МОНГОЛБАНК



МОНГОЛЫН МЭРГЭШСЭН
НЯГТЛАН БОДОГЧДЫН
ИНСТИТУТ

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОЛОН
САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД





Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр Монголбанкны дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн мэдээллийн албаны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://fiu.mongolbank.mn/> цахим хуудаснаас авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
ХУРААНГУЙ	6
УДИРТГАЛ	8
НЭГ. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ НЬ	9
1.1. Мөнгө угаах	9
1.2. Терроризмыг санхүүжүүлэх	10
1.3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх	12
1.4. Эрх зүйн зохицуулалт	12
1.5. Санхүүгийн мэдээллийн алба	14
1.6. Зөрчигчид хүлээлгэх хариуцлага	17
1.7. НББСЗҮҮ нь яагаад хуулар үүрэг хүлээсэн бэ?	17
1.8. Бодит жишээ, тохиолдолууд	19
1.8.1 Бодит жишээ 1: Татвараас зайлсхийсэн гэмт хэрэг үйлдсэн нь	19
1.8.2 Бодит жишээ 2. Нягтлан бодогчид болон хуульчид мөнгө угаах далд явуулгад дэмжлэг үзүүлсэн нь:	20
1.8.3 Бодит жишээ 3. Зохион байгуулалттай гэмт хэрэгт нягтлан бодогчид санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгсөн нь:	22
1.8.4 Бодит жишээ 4: Сэжигтэй гүйлгээг мэдээлсэн нь	22
ХОЁР. НББСЗҮҮ-ИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	24
ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БА ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛ	27
3.1.1 Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл	27
3.1.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл	28
3.1.3 Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл	28
ДӨРӨВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ (ХТМ)	30
ТАВ. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (STR)	31
ЗУРГАА. НУУЦЛАЛ, ХОРИГЛОХ ЗААЛТ	35
ДОЛОО. БАРИМТ МАТЕРИАЛЫН ХАДГАЛАЛТ	36
НАЙМ. СУРГАЛТ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ	37
ЕС. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	38

АНГЛИ НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Anti–money laundering / Countering the financing of terrorism /AML/CFT/	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТС/
Anti–money laundering / Countering the financing of terrorism law /AML/CFT Law/	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
Business relationship	Бизнесийн харилцаа
Beneficial owner	Эцсийн өмчлөгч
Customer due diligence /CDD/	Харилцагчийг таньж мэдэх
Client	Харилцагч
Designated Non–Financial Businesses and Professions /DNFBPs/	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид
Enhanced due diligence /EDD/	Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа
Financial Action Task Force /FATF/	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/
Financial Information Unit /FIU/	Санхүүгийн мэдээллийн алба
Family members of PEPs	УТНБЭ–ийн гэр бүлийн гишүүд
Money laundering /ML/	Мөнгө угаах
Money laundering offence	Мөнгө угаах гэмт хэрэг
Politically exposed person /PEP/	Улс төрд нөлөө бүхий этгээд
Preventive measures regulation /PMR/	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
Proceeds of crime	Гэмт хэрэг үйлдэж олсон орлого
Risk based approach /RBA/	Эрсдэлд суурилсан аргачлал
Record keeping	Баримт материалын хадгалалт
Suspicious Transaction	Сэжигтэй гүйлгээ
Terrorist financing /TF/	Терроризмыг санхүүжүүлэх

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНДМУТБ	Ази, Номхон далайн Мөнгө угаахтай тэмцэх бүлэг
НББСЗҮҮ	Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч
НУБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх

ХУРААНГУЙ

1. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид буюу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаанд ашиглах болжээ. Аливаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг нуун далдлах, хууль ёсны мэт харагдуулахын тулд СББМҮҮ–дийн үзүүлж буй мэргэжлийн үйлчилгээг ашиглах, тэдний зөвлөмж, зааварчилгааг авах, эрх зүйн тогтолцооны эмзэг сул байдлыг ашиглах зэргээр мөнгө угаах болон бусад хууль бус үйл ажиллагаанд оролцуулж байна.
2. СББМҮҮ нь санаатай болон болгоомжгүйгээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа учраас энэ чиглэлийн олон улсын стандарт тогтоогч байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–аас тодорхой үүргийг хэрэгжүүлэхийг шаардсан байна.
3. Энэхүү олон улсын стандартыг биелүүлэх зорилгоор МУТСТ тухай хуульд СББМҮҮ–дийг мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ) хэмээн тодорхойлсон бөгөөд хуульд заасан тодорхой үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай болсон.
4. Уг гарын авлага нь СББМҮҮ–дийн МУТСТ тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичигт заасан үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.
5. ФАТФ–ын олон улсын стандарт болон МУТСТ тухай хуульд МУТС–тэй тэмцэхэд эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Тиймээс СББМҮҮ нь МУТС үйл ажиллагаанд өртөх эрсдэлээ үнэлэх, эрсдэлийг бууруулах, болон эрсдэлд суурилсан тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэх шаардлагатай байна. Мөн эрсдэлд суурилсан тогтолцоог хэрэгжүүлснээр МУТСТ нөөц бололцоог зөв хуваарилах ач холбогдолтой билээ.
6. МУТСТ тухай хуульд заасны дагуу СББМҮҮ нь ямар харилцагчид үйлчилгээ үзүүлж байгаагаа мэдэх, тухайн этгээдийн үйлдэлд хянамгай хандах, хэрэв бизнесийн үйл ажиллагаанд тодорхой эрсдэл учруулж байвал хяналтын

үйл ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдэлтэй нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн үйлдлийг мэдээлэх, мэдээллийг хадгалах зэрэг үүргийг хэрэгжүүлэх ёстой. Мөн МУТС эрсдэлээс хамгаалах хяналтын тогтолцоог өөрийн үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээнд уялдуулан нэвтрүүлэх шаардлагатай байдаг. Энэ үүргийн биелэлтийг хангуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулан гаргасан бөгөөд цаашид гарын авлагыг сайжруулах, агуулгыг дэлгэрүүлэхтэй холбоотой үнэтэй санал хүсэлтийг бид хүлээн авч, шаардлагатай бол энэхүү гарын авлагад тусгах ажиллагааг зохион байгуулахад нээлттэй болно.

7. Гарын авлагыг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан тэдгээрийн онцлог, шинж бүхий бодит жишээ, тохиолдлуудыг оруулан боловсрууллаа.
8. Энэхүү гарын авлага нь зөвхөн СББМҮҮ–Д хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд дэмжлэг, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой.

УДИРТГАЛ

Гарын авлагын зорилго:

Энэхүү гарын авлагыг нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч хүн, хуулийн этгээдийн Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд МУТС–ээс урьдчилан сэргийлэх, МУТС эрсдэлийг удирдах, мэдээлэх үүргээ биелүүлэх болон бусад хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор боловсруулав.

Гарын авлагыг хэн ашиглах вэ?

Мөнгө угаах болон Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тухай хуулийн 4.1.9–д заасан МҮЭ болох Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч (НББСЗҮҮ) нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол энэхүү гарын авлагыг ашиглана:

- үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
- харилцагчийн хөрөнгийг удирдах;
- банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
- компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
- хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

НББСЗҮҮ гэдэгт дараах этгээдийг хамааруулна:

- Аудитын компани;
- Гэрээт аудитор;
- Гэрээт нягтлан бодогч;
- Татварын мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч хувь хүн, хуулийн этгээд.

НЭГ. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ НЬ

1.1. Мөнгө угаах

1.1.1. МУТС тухай хуульд **“Мөнгө угаах”** гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

1.1.2. Мөнгө угаах нь ихэвчлэн дараах үндсэн зорилготой. Үүнд:

- хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын эх үүсвэрийг өөрчлөх, шилжүүлэх;
- хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга болон эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх, нуун далдлах;
- хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого олж авах, эзэмших, ашиглах, үр шимийг нь хүртэх;
- мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд хамтран оролцох, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах, хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх гэх мэт.

1.1.3. Мөнгө угаах үйл ажиллагаанд санхүүгийн салбарын нарийн мэргэшсэн мэргэжилтнүүдээс гадна хувь хүн, хуулийн этгээд, СББМҮҮ буюу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, хуульч, нотариатч, НББСЗҮҮ–ийг оролцуулж ашиглах, гүйлгээ хийх нь түгээмэл байдаг. Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус хөрөнгө, орлогыг илрүүлэхэд олон салбарыг хамарсан өргөн хүрээний мэдлэг шаардлагатай болдог. Мөнгө угаагчид гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо олон улсын болон дотоодын зах зээл дээр ашиглагдаж байгаа төлбөр тооцооны хэрэгслүүд, өндөр өртөгтэй хөрвөх чадвартай үнэт металл, үнэт эдлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологи зэргийг ашиглан хэлбэр,

төрхийг нь хувиргахыг оролддог. МУТС үйл ажиллагаа нь байршуулах, нуун далдлах, буцаан төвлөрүүлэх гэсэн гурван үе шаттай үйлдэгддэг.

- **Байршуулах үе шат:** Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны болгож санхүүгийн системд байршуулах, мөнгөн тэмдэгтийг өөр дэвсгэрт, гадаад валютаар солиулах, бэлэн мөнгийг тээвэрлэх, эсвэл банкны дансанд байршуулах гэх мэт.
- **Нуун далдлах үе шат:** Хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын гарал үүслийг нуун дарагдуулах зорилгоор бэлэн бус шилжүүлэг хийх, өөр банкны дансанд байршуулах, банк хооронд хувааж, нийлүүлж шилжүүлэх, олон банк, санхүүгийн байгууллага, улс орнуудаар дамжуулан эх үүсвэрийг нуун далдлах гэх мэт.
- **Буцаан төвлөрүүлэх үе шат:** Хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын гарал үүслийг нуун дарагдуулах зорилгоор бэлэн бус шилжүүлэг хийх, өөр банкны дансанд байршуулах, банк хооронд хувааж, нийлүүлж шилжүүлэх, олон банк, санхүүгийн байгууллага, улс орнуудаар дамжуулан эх үүсвэрийг нуун далдлах гэх мэт.

1.1.4. Мөнгө угаахтай холбоотой дээрх үе шатуудад гэмт этгээдүүд нь хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны болгох үйл ажиллагаандаа НББСЗҮҮ, хуульч, нотариатч зэрэг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг ашиглан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын гарал үүсэл, шинж чанарыг нуун далдлах нарийн төвөгтэй схем, зохион байгуулалтад орж ажилладаг байна.

1.2. Терроризмыг санхүүжүүлэх

1.2.1. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд **“Терроризм”** гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдасг автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа гэж заасан.

1.2.2. МУТСТ тухай хуульд **“Терроризмыг санхүүжүүлэх”** гэж террорист

этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг хэлнэ гэж тодорхойлсон.

1.2.2. МУТС тухай хуульд **“Терроризмыг санхүүжүүлэх”** гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг хэлнэ гэж тодорхойлсон.

1.2.3. Мөнгө угаах үйл ажиллагааны гол сэдэл нь гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны болгох зорилготой байдаг. Харин терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн сэдэл нь хууль ёсны болон хууль бус хөрөнгө, орлогыг террорист үйл ажиллагаанд зарцуулахад оршдог.

1.2.4. Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбож үздэг. Гэвч агуулгын хувьд энэ хоёр төрлийн гэмт хэрэг нь тусдаа үйлдэгддэг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хууль ёсны мэт харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор ч бас санхүүжиж болдог.

1.2.5. Терроризмыг ихэвчлэн дараах эх үүсвэрээс олсон орлогоор санхүүжүүлдэг:

- их хэмжээний эд хөрөнгө хулгайлах;
- хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус худалдаа явуулах;
- хууль бус цагаачлал болон хүн худалдаалах;
- хүн барьцаалж, хулгайлах замаар төлбөр нэхэх;
- айлган сүрдүүлэх;
- хууль ёсны болон хууль бус орлогоос хандив тусламж өгөх
- (хувь хүн, төрийн бус байгууллага, хүмүүнлэгийн байгууллага гэх мэт).

1.3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх

1.3.1 Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд **“Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх”** гэж Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ гэж заасан.

1.4. Эрх зүйн зохицуулалт

1.4.1. Монгол Улс нь 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”–д нэгдэн орж, 2004 онд МУТСТ, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог ФАТФ–ын салбар байгууллага болох Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)–т элсэн орсноор МУТСТ олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээсэн.

1.4.2. Монгол Улсад анх 2006 оны 07 дугаар сард “МУТСТ тухай хууль” батлагдсан бөгөөд 2013, 2018, 2019 онд энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, олон улсын стандарт, шаардлагын дагуу МҮЭ–ээр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, нотариатч, хуульч, НББСЗҮҮ–ийг нэмсэн.

1.4.3. Ийнхүү дээрх МҮЭ нь МУмэТСТ тухай хуулийг хэрэгжүүлж, харилцагчийг таньж мэдэх (ХТМ), гүйлгээ эсхүл үйл ажиллагааны мэдээллийг СМА–нд мэдээлэх үүрэг, хариуцлага хүлээж байна.

1.4.4. Дараах диаграммд МУТСТ хууль эрх зүйн орчны өөрчлөлтийг он цагийн дарааллаар харууллаа.



1.4.5. НББСЗҮҮ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах хууль тогтоомж болон олон улсын стандартыг дагаж мөрдөнө:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25–ны өдрийн 463 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам”;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 21–ний өдрийн А–26 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25–ны өдрийн А–326 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”;
- Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журмын дагуу тайлан бөглөх заавар, зөвлөмж;
- ФАТФ–ын 40 зөвлөмж: Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт.

1.5. Санхүүгийн мэдээллийн алба

1.5.1. МУТСТ тогтолцооны нэг чухал шаардлага нь МҮЭ гэмт хэрэг болон террорист үйл ажиллагаанд холбогдолтой байж болзошгүй, сэжигтэй гэж үзсэн гүйлгээнүүдийг мэдээлэх юм. СМА нь МҮЭ–с сэжигтэй гүйлгээний мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, гэмт хэрэг болон террорист үйл ажиллагаанд холбоотой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд хууль сахиулах байгууллагуудад мөрдөн

шалгуулахаар хүргүүлдэг. Тиймээс улс орнууд гэмт хэрэг болон террорист үйл ажиллагаанд холбоотой байж болзошгүй санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий мэргэшсэн байгууллага буюу Санхүүгийн мэдээллийн албыг байгуулдаг.

1.5.2. Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 8–ны өдөр МУТСТ тухай хуулийг баталснаар Монголбанкны дэргэд Санхүүгийн мэдээллийн албыг байгуулж МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндэс, суурийг бий болгосон. Түүнчлэн Монгол Улс 2009 онд Эгмонт бүлэгт гишүүнээр элссэн бөгөөд СМА нь Монгол Улсыг төлөөлөн Эгмонт бүлгийн гишүүн орнуудын СМА–тай мэдээлэл солилцон хамтран ажиллах болсон.

1.5.3. МУТСТ тухай хуулийн 16.1–д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, МҮЭ–ээс сэжигтэй гүйлгээ, босго дүн давсан бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд МУТС–тэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага байна.

1.5.4. МУТСТ тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Санхүүгийн мэдээллийн алба нь тус хуульд заасны дагуу МУТС–эд ашиглаж байгаа гэж үзэх үндэслэл байгаа бол МҮЭ–ийн харилцагчийн дансанд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хөрөнгийг битүүмжлэх, гүйлгээг түдгэлзүүлэх;
- МҮЭ–ээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх;
- МУТС үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий

байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн сэжигтэй бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

- МҮЭ–ийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар тогтмол мэдээлэх;
- МУТС–тэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж МҮЭ–эд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;
- Хориг арга хэмжээний жагсаалтыг МҮЭ–эд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах;
- МУТСТ тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;
- МУТСТ Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний стратеги боловсруулах, уг стратегийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;
- МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах.

Хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.5.5. МУТСТ тухай хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

1.5.6. МУТСТ тухай хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол энэ хуулийн 19.1–д заасан байгууллагын эрх бүхий албан тушаалтан үүссэн нөхцөл байдал,

дутагдлыг харгалзан дараах арга хэмжээг авна:

- дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;
- энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;
- энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах;
- энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох.

1.5.7. Эрх бүхий албан тушаалтнаас МУТСТ тухай хуулийн 23.2–т заасны дагуу өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, сануулга, шаардлагыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

1.6. Зөрчилд хүлээлгэх хариуцлага

1.6.1. Зөрчлийн тухай хуулийн 5.10 дугаар зүйлд Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих, 11.29 дүгээр зүйлд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийг тус тус зааж, зөрчсөн тохиолдолд онгодуулах шийтгэлийг тусгасан.

1.6.2. Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тус тус заасны дагуу санхүүгийн мэдээллийн улсын байцаагч хүлээлгэнэ.

1.7. НББСЗҮҮ нь яагаад хуулиар үүрэг хүлээсэн бэ?

1.7.1. ФАТФ–аас нягтлан бодох бүртгэлийн салбарыг МУТС үйл ажиллагаатай хамааралтай эрсдэл бүхий салбар гэж үзсэн.

1.7.2. Нягтлан бодох бүртгэлийн салбарын мэргэжилтнүүд нь харилцагчдадаа

аудит баталгаажуулалтын үйлчилгээ, татварын зөвлөх үйлчилгээ, санхүүгийн тайлан бэлтгэх, бүртгэл хөтлөх зэрэг өргөн хүрээний үйлчилгээг үзүүлдэг тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд НББСЗҮҮ–дийг ашиглах эрсдэлийг нэмэгдүүлдэг.

- 1.7.3. Тухайлбал, санхүүгийн болон татварын зөвлөх үйлчилгээгээр дамжуулан гэмт этгээдүүд нь зөвлөгөө хүсч буй хэн нэгний дүрээр татвар болон бусад өр төлбөрөөс зайлсхийх зөвлөгөө авах, нягтлан бодогчдыг ашиглан бэлэн мөнгө данснаас авах, дансанд шилжүүлэх, гадаад улс орон луу шилжүүлэг хийлгэх зэргээр хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг нуун далдлах ажиллагааг гүйцэтгэдэг байна.
- 1.7.4. Мөнгө угаах зорилго бүхий этгээд нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид буюу хуульч, нотариатч, НББСЗҮҮ–ийг ашигладаг. ФАТФ–ын зөвлөмжид дурдсанаар нягтлан бодогчид нь “Gatekeeper” буюу “Манаач”–ийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд санхүүгийн системд аливаа мөнгө нэвтрэн орохын тулд хамгийн түрүүнд нягтлан бодогчдоор дамждаг. Тиймээс ФАТФ–ын Зөвлөмж 22–т эдгээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь эрсдэлээс урьдчилан сэргийлж, МУТСТ үүргээ хариуцлагатайгаар биелүүлэх шаардлагатайг онцолсон.
- 1.7.5. Монгол Улс МУТСТ олон улсын стандарт болох ФАТФ–ын 40 Зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор МУТСТ тухай хуулийг хэрэгжүүлж, стандартын шаардлагуудыг цаг алдалгүй дотоодын хууль эрх зүйн орчинд тусган ажиллаж байгаа билээ. Үүний хүрээнд НББСЗҮҮ–д хамаарах шаардлагуудыг МУТСТ тухай хуульд тусгаж, 2018 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 1.7.6. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь хуульд заасан үүргээ хэрэгжүүлснээр өөрсдийгөө МУТС гэмт хэрэгт холбогдох эрсдэлээс хамгаалах үндсэн зорилготой юм.
- 1.7.7. МУТСТ тухай хуульд заасан НББСЗҮҮ–ийн үүргийг ФАТФ–аас гаргасан гарын авлага, заавар зөвлөмжид дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. НББСЗҮҮ нь эдгээр баримт материалтай танилцаж, ойлголтоо

нэмэгдүүлэх нь зүйтэй. Тухайлбал, ФАТФ–аас гаргасан дараах баримт бичиг, гарын авлага байна:

- ФАТФ–ын 40 зөвлөмж болон түүний тайлбар хэсэг;
- НББСЗҮҮ–дэд хамаарах ФАТФ–ын 1, 10, 11, 12, 17, 19–25, 28, 35–р зөвлөмжүүд;
- ФАТФ–аас гаргасан “Ил тод байдал ба эцсийн өмчлөгч” гарын авлага;
- ФАТФ–аас гаргасан “Траст болон трастын үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлд суурилсан аргачлал” гарын авлага;
- ФАТФ–аас гаргасан “Нягтланбодохбүртгэлийн мэргэжилтнүүдэд зориулсан эрсдэлд суурилсан аргачлал” гарын авлага;

1.8. БОДИТ ЖИШЭЭ, ТОХИОЛДЛУУД:


1.8.1. Бодит жишээ 1. Татвараас зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн нь

АНУ–д хуулийн фирм болон жижиглэн худалдааны бизнес эрхэлдэг нэгэн этгээд өөрийн бизнесийн ашиг, орлогоо нуун дарагдуулж, татвараас зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн байна.

Тухайлбал, гэмт этгээд хуулийн фирмийн зөвлөх хийх явцдаа итгэмжлэлийн гэрээгээр харилцагчийнхаа дансыг чөлөөтэй удирддаг байсан бөгөөд тус харилцагчийн дансанд өөрийн олсон ашиг орлогыг хадгалж, түүнээсээ авах байдлаар хууль бус үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байсан. Энэхүү үйлдэл нь түүний өөрийнх нь татвар тооцох дансны үлдэгдлийг бага байлгаж, улмаар татварын байгууллагын хараа хяналтаас амжилттай бултаж татвараас зайлсхийх гэмт хэргийг даамжруулах боломжийг олгосон байна. Тэрээр 2 жилийн хугацаанд 300,000.00 ам долларын татвараас зайлсхийжээ.

Мөрдөн шалгах ажилтнууд сэжигтэй үйл ажиллагааны тайланг шалгаснаар өргөн цар хүрээний зохион байгуулалттай гүйлгээг олж харан, энэхүү хэргийг олж илрүүлжээ.

Удалгүй гэмт этгээд нь татвараас санаатайгаар зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, шүүхээс 1 жилийн хорих ял, үргэлжлүүлэн 3 жилийн тэнсэн харгалзах ялаас гадна маш өндөр хэмжээний татвар, хүүг төлөх, торгууль төлөх ялаар шийтгүүлсэн байна.



1.8.2. Бодит жишээ 2. Шинэ Зеландын нууц мөрдлөгөөр илэрсэн гэмт хэрэг


Шинэ Зеландын цагдаагийн байгууллага мөрдөн шалгах нууц ажиллагаагаар дараах хэргийг илрүүлжээ. Мансууруулах бодис худалдаалсан гэмт этгээдүүд нь нарийн төвөгтэй бүтэц бүхий хуулийн этгээдийг үүсгэн байгуулж, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо нуун дарагдуулах зорилгоор нягтлан бодогч, траст зэрэг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг ашигласан байна. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах гэмт хэрэг үйлдэхдээ олон төрлөөр ашиглаж байгааг энэхүү хэргээс харж болно. Тухайлбал:

- ФАТФ–ын 40 зөвлөмж болон түүний тайлбар хэсэг;
- хөрөнгийг удирдаж буй компаниудын эцсийн өмчлөгч, хяналтыг далдлах зорилготойгоор хуулийн этгээдийг үүсгэн байгуулах;
- мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг ашиглан цогц бүтцийг бий болгохоос гадна тэднийг зуучлагчаар ашиглах;
- трастын үйлчилгээг ашиглан гэмт хэргийн хамаарал бүхий гүйлгээг далдлах.

Гэмт этгээд нь мансууруулах бодис худалдаалж олсон орлогоор трастын үйлчилгээг ашиглан сэтгүүлийн бизнесийн хувьцаа болон компанийг худалдан авчээ. Гэмт этгээдийн унадаг машин дараа нь

тус компанийн нэр дээр бүртгэгдсэн бөгөөд энэ нь гэмт этгээд өөрийн нэр дээр хөрөнгө бүртгүүлэхээс зайлсхийсэн ажиллагаа байв.

Түүнчлэн гэмт этгээд өөрийн нягтлан бодогчийг зуучлагчийн дүрээр ашиглаж санхүүгээ нуун далдлах ажиллагаанд дахин нэг давхарга нэмсэн байна. Эцэст нь гэмт хэрэгтэн сэтгүүлийн бизнес болон тээврийн хэрэгслийн эцсийн өмчлөгчийг нуун дарагдуулах зорилгоор нягтлан бодогч, трастыг ашиглажээ. Тухайлбал: Гэмт этгээдийн амьдардаг байр нэгэн компанийн нэр дээр байсан бөгөөд тэрхүү компани өөрийнх нь нягтлан бодогчийн трастын компанийн хувьцаа эзэмшигч байв. Нягтлан бодогчийн трастын компани нь гэмт этгээдийн трастын өмнөөс хувьцааг нь эзэмшиж байсан



1.8.3. Бодит жишээ 3. Нягтлан бодогчид зохион байгуулалттай гэмт бүлэгт санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгсөн нь

Хууль сахиулах байгууллагын ажилтнууд нэгэн байгууллагын нягтлан бодогч У–г Х гэх этгээдээр удирдуулан, хар тамхины наймаанаас олсон хууль бус, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоор хөрөнгө оруулалт хийн, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байсныг илрүүлжээ.

У нь банкуудын дотоод, гадаад үйл ажиллагаа, олон улсын санхүүгийн хэрэгслийн талаар өндөр мэдлэг, туршлагатай мэргэжилтэн юм. Тэрээр Х–ийн гэмт хэрэг үйлдэж олсон орлогоор хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой санхүүгийн асуудлыг хариуцсан гол ажилтан нь байсан.

У нь тус байгууллагад хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээг үзүүлдэг байсан бөгөөд байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуулийн болоод техник шинжилгээ хийж, санхүүгийн тайлангийн талаас нь тухайн хөрөнгө оруулалтыг хууль ёсны мэт харагдуулах хамгийн боломжит хувилбарыг олох ажлыг хийдэг байжээ. Жишээлбэл, тэрээр зээл, худалдаа, хөрөнгө оруулалтын гэрээнүүд байгуулан, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гадаадын компаниуд болон банк, санхүүгийн байгууллагуудын хооронд цахим гүйлгээ хийх замаар хууль ёсны харагдуулах арга хэмжээг авсан байна.

1.8.4. Бодит жишээ 4. Сэжигтэй гүйлгээг мэдээлсэн нь

Нягтлан бодогч А нь гэмт хэрэгтэнд үйлчилгээ үзүүлж, өөрийн компанийн дансаар дамжуулан 50,000 ам.долларыг харилцагчийн дансанд шилжүүлсэн. Эхэндээ тус мөнгө нь гэмт хэргийн гарал үүсэлтэйг нягтлан бодогч мэдээгүй боловч дараа нь сэжигтэй гүйлгээг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэж, мэдэгдсэн гэдгээ харилцагчаасаа нуун үргэлжлүүлэн үйлчилгээ үзүүлсээр байжээ. Хожим нягтлан бодогчийг зохион байгуулалттай гэмт хэрэгт ашиглагдсан, гэм зэмгүй гэж шүүхээр шийдвэрлэсэн байна.

1.8.5. Дээрх жишээнүүдээс дүгнэхэд НББСЗҮҮ хүн, хуулийн этгээд нь МУТСТ үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд томоохон үүрэгтэй болох нь харагдаж байна. Нэг талаас НББСЗҮҮ

нь өөрсдийн МУТС эрсдэлийг урьдчилан хараагүй, ХТМ ажиллагааг хангалтгүй хийх, мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд МУТС зорилго бүхий гэмт этгээдүүдэд ашиглагдах, цаашлаад тэдний явуулгад өртөж өөрөө хохирох уршигтай гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

- 1.8.6. Зарим нягтлан бодогчид нь татвараас зайлсхийх, бусад татвар төлөгчидтэй үгсэн хуйвалдаж санхүүгийн баримт материалыг хуурамчаар үйлдэх тохиолдол гардаг. Тэд татвар ногдох үйл ажиллагааг нуух, дүнг нь багасгаж тайлагнах, өртөг зардлаа зохиомлоор өсгөж санхүүгийн болон татварын тайланг хуурамчаар бэлтгэх замаар мэргэжлийн ёс зүйгүй үйлдэл гаргаж мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг нэмэгдүүлдэг.
- 1.8.7. Иймд НББСЗҮҮ–д нь мэргэжлийн өндөр ёс зүйтэй байж, МУТС–ээс урьдчилан сэргийлэх эрсдэлд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, сэжигтэй гүйлгээг мэдээлэх нь нэн чухал юм.

ХОЁР. НББСЗҮҮ–ИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 2.1. МУТС–тэй холбоотой үүсэх эрсдэл нь МҮЭ тус бүрт харилцан адилгүй байдаг ба санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг хүргэх хэлбэр, газар зүйн байршил, харилцагчдын төрөл зэрэг маш олон хүчин зүйлээс хамаарна. НББСЗҮҮ нь үүсч болзошгүй эрсдэлийг удирдах, бууруулах арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай. Эдгээр арга хэмжээг авснаар гэмт этгээдэд ашиглуулахаас хамгаалах, бохир мөнгийг санхүүгийн системд байршуулахаас сэргийлэх чухал ач холбогдолтой. Тиймээс МУТС тухай хуульд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, ХТМ, сэжигтэй гүйлгээг мэдээлэх зэрэг чухал үүргийг нарийвчлан тусгасан.
- 2.2. МҮЭ нь өөрийн удирдлагаас баталсан МУТС–д чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байх ба шат шатны удирдлага, ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай. Энэхүү хөтөлбөрт хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх хэрэгтэй.



- 2.3. Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ) нь НББСЗҮҮ–д МУТС тухай хуульд заасны дагуу үр дүнтэй хяналтын хөтөлбөртэй эсэх, түүнийгээ мөрдөж, хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих үүрэг бүхий өөрийгөө зохицуулах байгууллага юм. НББСЗҮҮ–ийн МУТС–тэй холбоотой баримт бичиг, дүрэм, журам нь ММНБИ, СМА зэрэг зохицуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шаардлагуудтай нийцэх ёстой.
- 2.4. НББСЗҮҮ нь хүн, хуулийн этгээд байхаас үл хамааран дотоод хяналтын хөтөлбөртэй байна. Томоохон салбар нэгж бүхий хуулийн этгээд байх тохиолдолд түүний бүх салбар нэгж, охин компани нь дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой.

- 2.5. Дотоод хяналт гэдэг нь МУТСТ эрсдэлийг хязгаарлах, удирдах, дагаж мөрдөх тухай МҮЭ–ийн бодлогын баримт бичиг юм. Дотоод хяналтын хөтөлбөр нь МҮЭ–ийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцсэн байх ба МУТС эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг хангасан байна.
- 2.6. МУТСТ тухай хуульд заасны дагуу НББСЗҮҮ нь дотоод хяналтын хөтөлбөрийг ММНБИ–д хүргүүлж, бүртгүүлэх шаардлагатай. Дотоод хяналтын хөтөлбөрт дараах зүйлсийг тусгана:
- харилцагчдыг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх үйл ажиллагаанд мутс эрсдэлийг үнэлэх аргачлал;
 - шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалт;
 - ХТМ үйл ажиллагаа, ХТМ нарийвчилсан үйл ажиллагааны журам;
 - өндөр эрсдэл бүхий ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;
 - ХТМ үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд дагаж мөрдөх зохицуулалт;
 - сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, сма болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журам;
 - НҮБ–ын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;
 - тусгайлан хяналт тавих үйл ажиллагааны журам;
 - МУТСТ тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;
 - МУТСТ тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр;
 - хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан бусад нөхцөл, шаардлага.

- 2.7. МУТСТ эрсдэлд суурилсан аргачлалын хэрэгжилтийг хангахын тулд НББСЗҮҮ нь комплаенсын ажилтныг томилно. Комплаенсын ажилтан нь МУТС гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, илрүүлэх, зогсоох, үр дүнтэй арга хэмжээ авахад онцгой үүрэгтэй. Иймд комплаенсын ажилтан нь ажлын дадлага туршлага, мэдлэг чадвар, боловсролтой байх нь нэн чухал бөгөөд байгууллагын дээд шатны удирдлагаас томилох хэрэгтэй.
- 2.8. Комплаенсын ажилтан нь МУТСТ чиглэлээр тодорхой чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг. Үүнд МУТСТ тухай хууль болон дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, НББСЗҮҮ–ийн МУТСТ байгууллагын соёлыг бий болгож, хэвшүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх, СГТ–д дүн шинжилгээ хийх ажилд хяналт тавих, сэжигтэй гүйлгээг мэдээлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох маягтын дагуу СМА–нд хүргүүлэх арга хэмжээг авах, НББСЗҮҮ–ийн ажилтнуудыг МУТСТ тухай сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах зэрэг чиг үүргүүд багтана.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БА ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛ

3.1. МУТСТ тухай хуулийн 4.1–д заасан МҮЭ нь МУТСТ үйл ажиллагааг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ:

- харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл;
- бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;
- газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл.

3.1.1. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл:

НББСЗҮҮ хүн, хуулийн этгээд нь аливаа үйлчилгээг үзүүлэхээсээ өмнө өөрийн харилцагч, түүний эцсийн өмчлөгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй эсэхийг үнэлэх нь зүйтэй. Харилцагчийн эрсдэл гэдэг нь харилцагчаас үүсэх МУТС ерөнхий эрсдэл юм. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тодорхойлсноор тухайн бизнестэй холбоотой этгээдүүдийг үнэлэх цар хүрээг тодорхойлоход тусалдаг. Харилцагч байгууллагын нарийн төвөгтэй зохион байгуулалтын бүтэц болон мэдээллийг хэт нууцлах бодлого зэрэг нь МУТС–тэй холбоотой эрсдэлийг нэмэгдүүлж, тухайн ХТМ нарийвчилсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл болж болно. Тухайлбал, харилцагч, эсвэл түүний эцсийн өмчлөгч нь УТНБЭ байх тохиолдолд ХТМ нарийвчилсан арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлс:

- хэвийн бус нөхцөлөөр үүссэн бизнесийн харилцаа (жишээлбэл, гадаад улсаас биечлэн ирэхгүйгээр үүсгэж буй бизнесийн харилцаа);
- оршин суугч бус харилцагч;
- хэлцлийн үндсэн дээр хөрөнгийг хариуцаж, удирдаж байгаа харилцагч;
- харилцагч нь нарийн төвөгтэй өмчлөлийн хэлбэртэй хуулийн этгээд.

3.1.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл:

Бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарах эрсдэл гэдэг нь тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг МУТС зорилгоор ашиглах боломжтой эмзэг байдлын илэрхийлэл юм. НББСЗҮҮ хүн, хуулийн этгээд нь аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид санал болгохын өмнө МУТС үйл ажиллагаанд ашиглагдах эрсдэлтэй эсэхийг үнэлэх хэрэгтэй бөгөөд МУТС эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд илүү их хяналт тавих шаардлагатай.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарах эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлс:

- эцсийн өмчлөгчийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас нуун далдлах боломжийг бүрдүүлж буй үйлчилгээ;
- шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- харилцагчийн талаар хангалттай мэдээлэл авахгүйгээр хийх боломжтой санхүүгийн эсхүл татварын зөвлөх үйлчилгээ;
- баталгаажуулалт хийхгүйгээр харилцагчийн данс болон хөрөнгийг удирдах, хадгалах үйлчилгээ.

3.1.3. Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл:

НББСЗҮҮ хүн, хуулийн этгээд нь аливаа бизнесийн харилцаа тогтоохын өмнө тухайн харилцагчийн үүсгэн байгуулагдсан улс орныг судалж, МУТС эрсдэлтэй улс орноос гаралтай эсэхийг үнэлэх хэрэгтэй. Харилцагчийн гарал үүслийг илэрхийлэх улс орны авлига, гэмт хэргийн үзүүлэлт, МУТС–тэй холбоотой хяналт шалгалтын тогтолцоо зэрэг хүчин зүйлсийг харгалзан газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэлийг тодорхойлно.

Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэлийн хүчин зүйлс:

- ФАТФ–аас МУТСТ стратегийн дутагдалтай гэж тодорхойлсон улс орнууд (ФАТФ, түүний Ази, Номхон далайн болон Евро–Ази зэрэг бүсийн байгууллагуудын хийсэн харилцан үнэлгээний тайланг харгалзан үзэх шаардлагатай);

- санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалт, бусад ижил төстэй арга хэмжээнд орсон улс орнууд;
 - найдвартай эх сурвалжаас авлига, хээл хахууль, гэмт хэргийн үзүүлэлт өндөртэй гэж тодорхойлогдсон улс орнууд;
 - найдвартай эх сурвалжаас тухайн улс орон эсхүл бүс нутаг нь терроризмыг санхүүжүүлдэг, террорист үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг эсхүл террорист бүлэглэл үйл ажиллагаа явуулдаг гэж тодорхойлогдсон улс орнууд.
- 3.2. НББСЗҮҮ нь бусад МҮЭ–ийн нэгэн адил эрсдэлийн үнэлгээ хийж, түүнд ашигласан мэдээллийг баримтжуулан тухай бүр шинэчлэн хадгалах бөгөөд эрх бүхий байгууллагаас шаардсан үед гаргаж өгөхөд бэлэн байлгана. НББСЗҮҮ нь эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан тухайн эрсдэлийг удирдах, бууруулахад чиглэсэн оновчтой арга хэмжээг МУТСТ дотоод хяналтын хөтөлбөр, бодлого, журамд тусгана. Өндөр эрсдэлтэй харилцагчийн хувьд эрсдэлийг удирдах болон бууруулах нэмэлт арга хэмжээг авна.
- 3.3. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар эрсдэлийг удирдана:
- 3.3.1. харилцагч, түүний эцсийн өмчлөгч, ашиг хүртэгч этгээд болон тэдгээрийн гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах;
- 3.3.2. гүйлгээ хийж байгаа этгээд, харилцагч, түүний эцсийн өмчлөгчийн талаар хангалттай мэдээлэлтэй байх шаардлагатай. энэ хүрээнд мүү–тэй үүсгэж буй бизнесийн харилцааны зорилго, хөрөнгө, орлогын гарал үүсэл, харилцагчийн эрхэлдэг ажил үйлчилгээ, бизнесийн цар хүрээний талаар мэдээлэл гаргуулж авах;
- 3.3.3. өндөр эрсдэлтэй гэж үзсэн харилцагч, түүний санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон газарзүйн байршилтай уялдуулан ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх;
- 3.3.4. харилцагчтай үүсгэсэн санхүү, бизнесийн харилцаа, гүйлгээ нь тухайн харилцагчийн талаарх холбогдох мэдээлэл болон хөрөнгө, орлогын эх үүсвэрийн мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих;






ДӨРӨВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ (ХТМ)

- 4.1. ХТМ гэдэг нь харилцагчийг тодорхойлох мэдээллийг харилцагчаас гаргуулж авах бөгөөд хэнийг төлөөлж байгаа, ямар үйл ажиллагаа явуулдаг, ямар зорилгоор харилцаж байгаа зэрэг мэдээллийг тодруулах, тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны бичиг баримт, төрийн байгууллагын мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглан мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь харилцагчийн болон түүний төлөөлж байгаа этгээдийн эцсийн өмчлөгч, харилцагчийн бизнесийн үр шим хүртэгч этгээд, удирдах эрх бүхий этгээдийг тодорхойлох, мэдээллийг баталгаажуулах зорилготой юм.
- 4.2. НББСЗҮҮ болон бусад МҮЭ нь ХТМ арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дараах ач холбогдолтой:
 - 4.2.1. НББСЗҮҮ нь өөрийн үйл ажиллагааг МУТС аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашлаад санхүүгийн системийг уг эрсдэлээс хамгаалах;
 - 4.2.2. НББСЗҮҮ–ийн харилцагчдаа үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглан гэмт хэрэг үйлдэх, үйлдэхээр завдсан гэмт хэргээс зайлсхийх;
 - 4.2.3. НББСЗҮҮ–ийн нэр хүндэд муугаар нөлөөлөх, санхүүгийн алдагдалд оруулах эрсдэлтэй, сэжигтэй гүйлгээ болон үйлдлийг илрүүлэх, тайлагнах;
 - 4.2.4. НББСЗҮҮ нь өөрийн бизнесийг тогтвортой үргэлжлүүлэх.
- 4.3. МУТСТ тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу НББСЗҮҮ болон бусад МҮЭ нь дараах тохиолдолд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй:
 - 4.3.1. бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;
 - 4.3.2. дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют), түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
 - 4.3.3. харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөгөөс бага боловч, нийт үнийн дүн нь 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх

- хэмжээний гадаад валют), түүнээс дээш үнийн дүнтэй бол;
- 4.3.4. харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;
- 4.3.5. тухайн харилцагч, тухайн гүйлгээг му болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.
- 4.4. Харилцагчийг таньж мэдэх 3 төрөл байдаг:
- 4.4.1. ХТМ хэвийн үйл ажиллагаа буюу энэ нь бүх харилцагчид хамааралтай;
- 4.4.2. Хялбаршуулсан байдлаар ХТМ үйл ажиллагаа буюу эрсдэл багатай харилцагчид хамааралтай;
- 4.4.3. Хялбаршуулсан байдлаар ХТМ үйл ажиллагаа буюу эрсдэл багатай харилцагчид хамааралтай;
- 4.5. Харилцагчийн мэдээллийг баталгаажуулах ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А–26 дугаар тушаалын хавсралтаар баталсан “МУТС–ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”–д заасан шаардлагын дагуу хийнэ. Энэ нь МҮЭ–ийн харилцагч, түүний эцсийн өмчлөгч, эсхүл харилцагч нь хуулийн этгээд эсхүл хөрөнгийг удирдах хэлцлийн дагуу хөрөнгийг хариуцаж байгаа бол түүнийг өмчилдөг, удирддаг эсхүл үр шим хүртэгч этгээдийг тодорхойлох, мэдээллийг шалгах, баримтжуулах зорилготой юм. Харилцагч нь олон шатлалт бүтэцтэй бол эцсийн өмчлөгч, удирдлагыг тодорхойлох хүртлээ өмчлөлийн шатлал тус бүр дэх этгээдүүдийг тодорхойлж, мэдээллийг нь шалган баримтжуулах шаардлагатай.

ТАВ. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (STR)

- 5.1. НББСЗҮҮ нь МУТСТ тухай хуульд заасан үйл ажиллагааг харилцагчдаа үзүүлэх явцад тухайн гүйлгээ, үйлдэл нь МУТС эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн эсвэл мэдсэн бол тухайн гүйлгээ болон үйлдлийг сэжигтэй гэж үзнэ.
- 5.2. Сэжигтэй гүйлгээ, үйлдэл нь харилцагчийн төрөл, санхүүгийн байдал, бизнесийн үйл ажиллагааны онцлог зэргээс шалтгаалан харилцан адилгүй байж болно. НББСЗҮҮ болон бусад МҮЭ нь гүйлгээ, үйлдэл, оролдлого хийгдсэн эсхүл хийгдэх гэж байгаагаас үл хамааран МУТС эрсдэлийг үнэлж дүгнэн, сэжиглэх үндэслэлийг тодорхойлох хэрэгтэй.
- 5.3. МУТС–тэй эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой байж болзошгүй гүйлгээ, үйлдэл, оролдлогыг сэжиглэх үндэслэлд ямар нэг босго дүн гэж байхгүй бөгөөд дүн харгалзалгүй СМА–нд мэдээлнэ.
- 5.4. НББСЗҮҮ хүн, хуулийн этгээд нь сэжигтэй гүйлгээ, үйлдлийг дараах байдлаар мэдээлж, хяналт тавьж ажиллана:



- 5.5. Сэжигтэй гүйлгээг тогтсон нийтлэг шинжээр тодорхойлох боломжгүй хэдий ч дараах нийтлэг шинж нотариатын үйлчилгээний салбарт байна:
- 5.5.1 харилцагч нь өөрийн орлогоос давсан эд хөрөнгийг эзэмшдэг бөгөөд тухайн хөрөнгийн эх үүсвэр тодорхой бус;
 - 5.5.2 өөрийн нэр дээр тогтмол хийдэг гүйлгээ нь тухайн этгээдийн ажил эрхлэлтийн байдалтай үл нийцэж байгаа;
 - 5.5.3 хууль, журамд заасан мэдээлэл өгөхөөс тогтмол татгалздаг/илт түвэгшээдэг;
 - 5.5.4 өмнө хийж заншсан гүйлгээний давтамж, төрөл, хэмжээ тодорхойгүй шалтгаанаар огцом өөрчлөгдсөн;
 - 5.5.5 хуурамч (хуурамч гэж сэжиглэх үндэслэлтэй) бичиг баримтад үндэслэн гүйлгээ хийж байгаа;
 - 5.5.6 санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа ажилтанд хууль бусаар нөлөөлөх замаар гүйлгээ/ үйлдэл хийхийг оролдож байгаа;
 - 5.5.7 МУТСТ хяналтын механизм бүрдээгүй улсаар дамжуулан хийсэн;
 - 5.5.8 тушааж байгаа үйлчилгээний хөлс, бүтээгдэхүүн борлуулсны орлого хэт үнэмшилгүй байгаа;
 - 5.5.9 олон хүн хангалттай мэдээлэл өгөлгүйгээр нэг дансанд бага бус дүнтэй мөнгө хийж байгаа;
 - 5.5.10 гэрээ хэлцэлтэйгээ үл нийцэж байгаа гүйлгээ;
 - 5.5.11 гадаадын орноос орж ирээд богино хугацааны дотор бүтнээр буцаж гарсан гүйлгээ;
 - 5.5.12 шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл дутуу;
 - 5.5.13 харилцагч нь жил бүр данс тооцоог хөтлөгч, нягтлан бодогчоо сольж байсан;
 - 5.5.14 харилцагч нь өөрийн байгууллагын бичиг баримтын хадгалалтын байршлыг мэдэхгүй, баримт бичгүүд хаана байгаа нь тодорхойгүй;
 - 5.5.15 компани нь одоогийн санхүүгийн тайландаа авлага, өглөгийг байнга тусгадаг боловч тооцоо нийлдэггүй, эсвэл огт байхгүй;
 - 5.5.16 компани нь ямар ч ажилтангүй, бизнесийн үйл ажиллагаа нь түгээмэл бус;
 - 5.5.17 компани нь оффшор компанид хэвийн бус, хэт их хэмжээтэй зөвлөх үйлчилгээний төлбөр төлдөг;

- 5.5.18 компани нь өөрсдийн зарлагыг орлогоосоо давуулан тайлагнаж, алдагдалтай мэт харагдуулдаг хэдий ч үндэслэлгүйгээр үргэлжүүлэн үйл ажиллагаа явуулдаг;
- 5.5.19 компани нь ашиг олохгүй байгаа ч хэрхэн үйл ажиллагаагаа тогтмол үргэлжлүүлж байгаа нь тодорхойгүй;
- 5.6. НББСЗҮҮ хүн, хуулийн этгээд нь СМА–нд мэдээлэл ирүүлэхдээ “СМА–нд МҮЭ–ээс цахимаар мэдээлэл ирүүлэх журмын дагуу тайлан бөглөх заавар, зөвлөмж”–ийг баримтална.
- 5.7. СМА нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг НББСЗҮҮ–ээс гаргуулан авах эрхтэй.

ЗУРГАА. НУУЦЛАЛ, ХОРИГЛОХ ЗААЛТ

- 6.1. СМА нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг НББСЗҮҮ–ээс гаргуулан авах эрхтэй.
- 6.2. МУТС тухай хуульд заасны дагуу НББСЗҮҮ, түүний удирдлага, ажилтан нь СМА–нд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.
- 6.3. НББСЗҮҮ–д тайланд холбогдсон харилцагч/үйлчлүүлэгч, хувь хүн, хуулийн этгээдэд түүний тухай мэдээллийг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа эсхүл мэдээлсэн тухай мэдэгдэхийг хориглоно.
- 6.4. НББСЗҮҮ хүн, хуулийн этгээдийн өгсөн мэдээлэл МУТС зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

ДОЛОО. БАРИМТ МАТЕРИАЛЫН ХАДГАЛАЛТ

- 7.1. МУТСТ тухай хуулийн 8.1–д заасны дагуу НББСЗҮҮ хүн, хуулийн этгээд нь харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд тус тус заасны дагуу олж авсан мэдээлэл, баримт бичгийг тухайн данс хаагдсан, эсхүл гүйлгээ хийгдсэнээс хойш 5–аас доошгүй жилийн хугацаанд хадгална:
 - 7.1.1. Харилцагчийн данс нээх, бизнесийн харилцаа үүсгэхэд ашигласан бичиг баримт, ХТМ хүрээнд олж авсан бичиг баримтууд, биеийн байцаалтын хуулбарыг данс хаагдсанаас эсхүл бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш 5–аас доошгүй жил, тохиолдлын чанартай гүйлгээ хийсэн бол гүйлгээ хийгдсэнээс хойш 5–аас доошгүй жил хадгална.
 - 7.1.2. Харилцагчийн мэдээллийг нарийвчлан шалгах явцад олж авсан баримт, мэдээлэл, харилцагчийн мэдээлэлд орсон өөрчлөлт, нэмэлт баримт, мэдээлэл, дансны мэдээлэл, корреспондент харилцааны гэрээ, санамж бичиг, МУТС эрсдэлийг тодорхойлоход ашигласан мэдээлэл, ХТМ тусгайлсан хяналтын дүгнэлт, сэжигтэй гүйлгээтэй холбоотой баримт, материалыг харилцаа дуусгавар болсноос хойш 5–аас доошгүй жил хадгална.
 - 7.1.3. Бэлэн болон бэлэн бус гүйлгээний баримтуудыг гүйлгээ хийгдсэнээс хойш 5–аас доошгүй жил хадгална.
- 7.2. МУТСТ тухай хууль болон МУТС–ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд зааснаар хадгалах баримт нь гүйлгээтэй холбоотой мэдээллийг сэргээж харах боломжтой, холбогдох бүх мэдээллийг агуулсан байх ба хуульд заасан эрх бүхий этгээдийн мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.
- 7.3. МУТСТ хуулийн дагуу НББСЗҮҮ нь баримт материалыг нотлох баримтын түвшинд ашиглах боломжийг хангаж байхаар архивлаж хадгална.

НАЙМ. СУРГАЛТ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ

- 8.1. МУТСТ тухай хуулийн 14 дүгээр зүйл болон ФАТФ–ын Зөвлөмж 18–д заасны дагуу НББСЗҮҮ нь дотоод хяналтын хөтөлбөрийн хүрээнд МУТСТ тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөртэй байна.
- 8.2. МУТСТ тухай сургалтыг тогтмол зохион байгуулах бөгөөд сургалтын агуулгыг хууль эрх зүйн орчин, нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээ, ажилтнуудын ажил үүргийн онцлог зэрэг хүчин зүйлстэй уялдуулан тогтмол шинэчилнэ. Ингэснээр ажилчид сүүлийн үеийн мэдээлэл, хандлагын талаарх ойлголттой болж МУТСТ үүргээ үр дүнтэй биелүүлэх боломжтой болно.

ЕС. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- **AML/CFT Guidance for Accountants**, Financial Intelligence Unit of Trinidad and Tobago, 2015, <https://www.fiu.gov.tt/wp-content/uploads/AMLCFT-Guidance-for-Accountants-Revised-as-at-September-2015-2.pdf>
- **Anti-money laundering guidance for accountancy sector**, CCAB–Accountants for Growth, 2018, <https://www.ccab.org.uk/documents/FinalAMLGuidance2018Formattedfinal.pdf>
- **APG Yearly typologies report 2015: Methods and Trends of Money Laundering and Terrorism Financing**, Asia Pacific group on Money Laundering – Sydney Australia : APG Secretariat, 2015, <http://www.apgml.org/documents/searchresults.aspx?key words=APG+Yearly+typologies+report+2015>
- **Case Studies on Fighting Money laundering, Terrorist Financing and Economic Crime**, ICPAC, 2018, <https://www.icpac.org.cy/zePortal/WebFiles/SELK/WebDocuments/Members/Specialized%20Technical%20Material%20-%20Guides/Anti%20Money%20Laundering/Case%20studies%20Pack%202018.pdf>
- **FATF Report on Money Laundering Typologies**, FATF, 2003–2004, <http://www.apgml.org/documents/search-results.aspx?keywords=FATF+Report+on+Money+Laundering+Typologies>
- **Helping professional accountants recognise and fight economic crime**, CCAB, 2016, <https://www.ccab.org.uk/documents/CCABEconomicCrimeCaseStudiesFINAL.pdf>
- **Risk-based Approach for the Accounting Profession**, FATF, 2019, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/RBA-Accounting-Profession.pdf>
- **Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад зориулсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага**, Санхүүгийн Зохицуулах Хороо.
- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай**, Монголбанк, 2019, <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/23.pdf>
- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль**, 2013, <https://www.legalinfo.mn/law/details/9242>

- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь**, Монголбанк, Олон нийтийн боловсрол мэдээллийн төв, 2018, <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/16.pdf>
- **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт**, ФАТФ, Монголбанк, 2012–2019, <https://www.mongolbank.mn/documents/cma/20180531F2.pdf>
- **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж**, Монголбанк, 2018, https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20180206_A32.pdf
- **Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам**, Монголбанк, 2019, https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20160920_terrorism.pdf
- **Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам**, Монголбанк, 2019, https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20191225_A326.pdf
- **Сэжигтэй гүйлгээ гэж юу вэ?**, Монголбанк, 2020, <https://www.mongolbank.mn/listCMA.aspx?id=2>
- **Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг илрүүлэхэд татварын албаны гүйцэтгэх үүрэг**, Б.Галбадрах С.Төгсжаргал, Монголын криминологичдын холбоо, 2014, <http://criminology.mn/post/188>
- **Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн нөхцөл байдал, түүнд нөлөөлж буй шалтгаан, хүчин зүйлд хийсэн дүн шинжилгээ**, Г.Золбоо, 2017, хуудас 6–8, <http://legaldata.mn/b/396>
- **Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль**, 2019, <https://www.legalinfo.mn/law/details/14696>
- **Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам**, 2019, <https://www.legalinfo.mn/annex/details/10532?lawid=15003>

